

“МОН-ИТ БУЛИГААР” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2022 оны 04-р сарын 20-ны өдөр

Дугаар 22-01

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2022 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 14:00 цагт ХУД-ийн 2-р хороо Арьс ширний үйлдвэрийн хашаанд байрлах өөрийн байранд зохион байгуулагдав. Хурлыг Мон-Ит Булигаар ХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Анхболд даргалж, Хувьцаа эзэмшигч нар оролцов.

Хурлын дарга Б.Анхболд: Та бүхний амар амгаланг айлтгая. Мон-Ит Булигаар ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал эхлэхэд бэлэн боллоо. Хурлаа албан ёсоор эхлүүлэхээс өмнө хурлыг албажуулах ёстой бөгөөд Тооллогын комиссын дарга Н.Анхцоожийг ирцийн мэдээллийг өгнө үү хэмээн хүсэж байна.

ХУРЛЫН ИРЦИЙГ ТАНИЛЦУУЛАХ:

Тооллогын комиссын дарга Н.Анхцоож: Мон-Ит Булигаар ХК-ийн 2022 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын ирцийг мэдээлье. 2022 оны 3 дугаар сарын 30-ны өдрөөр тасалбар болгон ХЭ-ийн бүртгэлээр Мон-Ит Булигаар ХК-ийн нийт саналын эрхтэй хувьцааны тоо 400,212 ширхэг байсан. 2022 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцогчдыг 2022 оны 03 дугаар сарын 30-ны өдрөөс 4 дүгээр сарын 20-ны өдрийн 14 цаг хүртэл бүртгэсэн бөгөөд өнөөдрийн хуралд 352,628 ширхэг саналын эрхтэй нийт 5 хувьцаа эзэмшигч оролцож, хурлын ирц 88.1 хувь болсноор Компанийн тухай хуулийн 69.1-д заасны дагуу хурлын ирц бүрдсэнийг мэдэгдэж байна.

ХУРЛЫН ДЭГИЙГ ТАНИЛЦУУЛАХ:

Хурлын дарга Б.Анхболд: Тооллогын комиссын дарга Н.Анхцоождоо баярлалаа. Ирц хуулийн шаардлагыг хангаж байгаа учир хурлаа албан ёсоор нээж байгааг мэдэгдэж байна. Хурлын дэгийг товч танилцуулахад Тооллогын комисс томилсон тухай ТУЗ-ийн тогтоолыг ТУЗ-ийн нарийн бичиг О.Маралмаа танилцуулна. Дараа нь хэлэлцэх асуудлын дагуу илтгэлүүдийг та бүхэнд хүргэнэ. Хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой асуултад хариулт өгнө. Санал хураалт явагдана. Тооллогын комисс санал хураалтын дүнг нэгтгээд үр дүнгээ танилцуулаад тогтоолын төслийг бидэнд танилцуулна. Үүнээс гарах шийдвэрүүдийг тогтоол болгож та бүхэнд танилцуулаад хурал албан ёсоор дуусах юм.

ТУЗ-ийн нарийн бичиг О.Маралмаа: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Хурлаар хэлэлцэх асуудлыг та бүхэнд танилцуулъя. Бид энэхүү хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэж, 7-н асуудал дээр санал авч шийдвэр гаргах байгаа.

1-рт. Компанийн 2021 оны үйл ажиллагааны тайланг танилцуулна.

- 2-рт. Компанийн 2021 оны үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг танилцуулж, баталгаажуулна.
- 3-рт. Компанийн 2021 оны санхүүгийн тайлан, түүнд хийсэн хараат бус аудитын дүгнэлтийг танилцуулна.
- 4-рт. Компанийн ногдол ашиг тараах тухай ТУЗ-ийн гаргасан тогтоолыг танилцуулна.
- 5-рт. ТУЗ-ийн үйл ажиллагаан зардлын төсөв танилцуулж, батлах тухай хэлэлцэн санал авна.
- 6-рт. Компанийн 2022 оны бизнес төлөвлөгөөг танилцуулна.
- 7-рт. Компанийн оноосон албан ёсны нэрийг Булигаар ХК болгож өөрчлөх тухай хэлэлцэн баталгаажуулна.
- 8-рт. Компанийн хувьцааг хуваах
- 9-рт. Хувьцаа нэмж гаргах, түүний тоог тогтоох
- 10-рт. Компанийн дүрмийг шинэчлэн батлах тухай болон 8,9,10-р асуудлыг та бүхэнд Ж.Эрдэнэбат танилцуулах бөгөөд уг асуудлуудыг хэлэлцэн санал авна.
- 11-рт. ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийн талаарх мэдээллийг та бүхэнд хүргэж санал хураалтаар шийдвэр гарна.

ТООЛЛОГЫН КОМИССЫГ ТАНИЛЦУУЛАХ:

Одоо Тооллогын комисс томилсон тухай ТУЗ-ийн тогтоолыг танилцуулъя. “Мон-ит булигаар” хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол 2022 оны 03 сарын 16-ны өдрийн Дугаар 06/22 Улаанбаатар хот, Тооллогын комисс томилох тухай, Мон-Ит Булигаар ХК-ийн 2022 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулахтай холбогдон, Тооллогын комиссыг томилох тухай асуудлыг хэлэлцэн, Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1 дэх заалт, Компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.32.4 дэх заалтыг тус тус үндэслэн тогтоох нь:

Нэг. Мон-Ит Булигаар ХК-ийн 2022 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Комиссын дарга: Н.Анхцоож, Гишүүд: Ю.Дүгэрмаа, Д.Энхзул

Хоёр. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан Тооллогын комисс /Анхцоож/-т дараах арга хэмжээг авч ажиллахыг даалгасугай. Үүнд:

1. Хурлын ирцийг бүртгэж хурлын даргад мэдээлэх;
2. Хурлаар хэлэлцэх асуудал тус бүрээр саналын эрхтэй байх хувьцааны тоо, төрлийг тодорхойлох;
3. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож, санал өгөх эрхээ хэрэгжүүлэхтэй холбогдон гарах аливаа асуултад тайлбар өгөх;
4. Санал өгөх журмыг тайлбарлах, хувьцаа эзэмшигчдийн санал өгөх эрхийг хангах;
5. Саналын хуудсыг тоолж, саналын хуудсыг хүлээн авах бөгөөд санал хураалтын дүнгийн тухай тэмдэглэл хөтлөх;
6. Саналын дүнг нэгтгэн, санал хураалтын дүнгийн тухай Тооллогын комиссын шийдвэрийг хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулах;
7. Саналын хуудсыг компанийн архивд хадгалуулахаар шилжүүлэх;

ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛУУДЫГ ТАНИЛЦУУЛАХ:

1-рт. Компанийн 2021 оны үйл ажиллагааны тайланг танилцуулах.

Гүйцэтгэх захирал Б.Анхболд: Хэлэлцэх асуудлын нэгдүгээрт бид эхлээд 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан танилцуулах байгаа. 2021 онд бид төлөвлөгөө, зорилго, зорилтоо ерөнхийдөө биелүүлсэн гэж үзэж байгаа. Мөн компанид тавигдаж байгаа байгаль орчны шаардлагын дагуу зарим саруудад үйл ажиллагаа зогсонги байсан. Зарим саруудад ажлууд шахагдаж өдөр шөнөгүй ажилласан компанийн нийт ажилчид удирдлагууддаа талархал илэрхийлье. Мон-Ит Булигаар ХК нь өнгөрсөн онд 5,2 тэрбум төгрөгийн борлуулалтын орлоготой ажилласан. Нийтдээ 548 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын ажил нэмж хийгдсэн. Өнгөрсөн жилийн нийт борлуулалтын 4,8 тэрбум төгрөгийг дотоодын зах зээлд борлуулсан. Гадаад руу анх удаагаа борлуулалт хийж 455 сая төгрөгийн борлуулалт хийж ажилласан. 387 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан. Өмнөх 2020 оны гүйцэтгэлтэй харьцуулсан 2021 онд Мон-Ит Булигаар ХК-ийн хувьд дотоодын зах зээл болон олон улсын зах зээл дээр бизнесийнхээ цар хүрээг өргөжүүлэх, үйлдвэрлэлийнхээ хүчин чадлыг нэмэгдүүлсэн өсөлттэй жил байлаа. 2021 онд компанийн нийт борлуулалтын орлого 5,298,742,188 төгрөг хүрч өмнөх оноос 78 хувийн өсөлттэй, дотоод борлуулалт өмнөх оноос 63 хувийн өсөлттэй байна. Бид 2021 оноос эхлэн гадаад зах зээл рүү борлуулалт хийж эхэлснээр нийт борлуулалтад гадаад борлуулалт 8.6 хувийг эзлэх болсон. Цаашид олон улсын гадаад зах зээл дээр бүтээгдэхүүнээ таниулж борлуулалтаа нэмэгдүүлэхээр ажиллаж байна. Арьс ширний нийт үйлдвэрлэлийн хувьд 187,555 ширхэг богийн, 76,082 ширхэг бодын арьс боловсруулсан нь өмнөх оноос 54 хувийн өсөлт гаргасан байна. 2019 оны 6 дугаар сараас хойш нийт 1,311,885,203 төгрөгийн хөрөнгө оруулалтыг бид үйлдвэрлэлийн бүтээмжийг өсгөх, мөн дэд бүтцийг сайжруулахад зарцуулаад байгаагаас 2021 оны хувьд 548,143,363 төгрөгийн хөрөнгө оруулалт хийсний 196,896,502 төгрөгийг үйлдвэрлэлийн зориулалттай тоног төхөөрөмж, 308,341,271 төгрөгийг барилга байгууламжийн бүтээн байгуулалт, 42,905,590 төгрөгийг бусад хөрөнгө оруулалтад зарцуулсан байна.

Дэлхийн арьс ширний боловсруулалтын чиг хандлага нь байгальд ээлтэй, цэвэр технологи руу чиглэж байгаа. Үүнээс гадна арьс ширний үйлдвэрлэл цэвэрлэх байгууламж барих шаардлага тавигдаж салбарын хэмжээнд тулгамдаад буй үйлдвэрийн бохирдлын асуудлыг өөрсдийн нөөц бололцоогоор бүрэн шийдвэрлэн 308,341,271 төгрөгийн хөрөнгө оруулалт хийж, үйлдвэрийн дэргэдэх бохир ус цэвэрлэх байгууламжийг саян энэ оны 3 дугаар сард ашиглалтад оруулсан байгаа. Шинээр ашиглалт орсон цэвэрлэх байгууламжийн хүчин чадал нь хоногт 150 куб.м үйлдвэрийн хаягдал усыг Монгол Улсын MNS:4943-2015 стандартын түвшинд хүргэж цэвэршүүлэх, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах зорилготой. Түүнчлэн бид борлуулалт маркетингийн ажлын хүрээнд жил болгон уламжлал ёсоор Leather Partners арга хэмжээг зохион байгуулдаг бөгөөд 2021 оны 10 дугаар сард 3 дахь жилдээ корпорэйт зочид буудалд зохион байгуулсан. Хэдийгээр цар тахалын хязгаарлалтай үе байсан чинь уг арга хэмжээнд арьс ширээр бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг 90 гаруй аж ахуй нэгж болон хувь хүмүүс оролцсон бөгөөд бидний зүгээс шинээр үйлдвэрлэн гарсан арьсны үзэсгэлэн гаргаж, сурталчлах, мөн харилцагч нараа урамшуулал шагнах арга хэмжээг зохиосон.

Нийт ажилтнуудын тоо 78 бөгөөд үүнээс захиргаа удирдлагын 12, үйлдвэрийн 66 ажилтантай.

Нийт ажилтнуудын хүйсийн хувьд 64 хувь эрэгтэй, 36 хувь эмэгтэй байгаа нь салбарын онцлог бөгөөд гэхдээ жендэрийн харьцааны хувьд ихээхэн боломжийн гэж үзэж байна. Харин нийт ажилтнуудын 65 орчим хувь нь 40 хүртэлх насны залуучууд эзэлж байна. Бид өнгөрсөн оны 11 дүгээр сард ажилтнуудынхаа цалинг нэмсэн бөгөөд дундаж цалинг 33% буюу үндсэн цалинг дунджаар 300,000 төгрөгөөр өссөн байгаа нь энэ цаг үед хамгийн сайн үзүүлэлт гэж дүгнэж байна. Ажилтнуудын тоо 25 хүнээр нэмэгдсэн бөгөөд ажлын байрны цомхтгол хийлгүй ажлын байрыг нэмэгдүүлсэн. Ажилтнуудынхаа эрүүл мэндийг хэвээр хадгалах, ажлын байранд дээр мэргэжлээс шалтгаалах өвчин үүсгэхгүй байх, урьдчилан сэргийлэн арга хэмжээг тогтмол хэрэгжүүлдэг. Нийт ажилтнуудын эрүүл мэндийг тандах, ердийн болон мэргэжлээс шалтгаалсан өвчнийг эрт үед илрүүлж, хөдөлмөрийн чадвар алдалтыг бууруулах зорилгоор 70 гаруй ажилтнаа эрүүл мэндийн хугацаат үзлэгт хамруулснаар ердийн болон мэргэжлээс шалтгаалах өвчлөлөөс урьдчилан сэргийлж ажиллаж байна.

Бидний хувьд өнгөрсөн хугацаанд Ковид-19-өөс шалтгаалсан хөл хорио, ажиллах хүчний хомсдол, тэвэр ложистик болон химийн материалын үнийн өсөлт зэрэг олон бэрхшээлүүд тулгарсан ч үйл ажиллагаагаа доголдолгүй хэвийн явуулахын цар тахлын нөхцөл байдалд тохирсон оновчтой арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлсний дүнд ашгийг боломжит хамгийн өндөр түвшинд хүргэн ажиллаж чадлаа.

2-рт. Компанийн 2021 оны үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг танилцуулах

ТУЗ-ийн дарга Б.Энхмэнд: Сайн байна уу. Мон-Ит Булигаар ХК-ийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгөх дүгнэлт, 2021 оны зорилтуудын талаарх илтгэлийг Компанийн тухай хууль, Мон-Ит Булигаар ХК-ийн дүрмийн хүрээнд Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэн, тус компанийн Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж байна.

Мон-Ит Булигаар ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь компанийн 2021 оны бизнес төлөвлөгөөг хэлэлцэн баталж, компанийг удирдах үйл ажиллагаандаа засаглалын зарчмууд, Компанийн тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомж болон компанийн дүрмийг мөрдлөг болгож, компанийн гүйцэтгэх удирдлагын баг нь Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр зөвлөмж, төлөвлөгөөт зорилтыг амжилттай хэрэгжүүлэн ажиллаж байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн баталсан 2021 оны бизнес төлөвлөгөө нь компанийн нийт борлуулалтын орлогыг өмнөх оноос 35 хувь өсгөх, бараа материалын үлдэгдлийн удирдлагыг сайжруулах, дуусахгүй үйлдвэрлэлийг 20 хувь бууруулах, бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулах, бүтээмжийг сайжруулахад онцгойлон анхаарах бодлогыг баримтлахад тус тус чиглэсэн билээ.

Мон-Ит Булигаар ХК 2021 онд 5,298,742 мянган төгрөгийн борлуулалтыг хийж, бизнес төлөвлөгөөг 2 дахин давуулан биелүүлсэн байна. Гадаад борлуулалтын төлөвлөгөөний биелэлтийг 100 хувь, дотоод борлуулалтын төлөвлөгөөний биелэлт 128 хувьд хүрчээ.

2019 оны 6 дугаар сараас хойш нийт 1,311,885,203 төгрөгийн хөрөнгө оруулалт хийсний тайлант жилд 548.143.363 төгрөгийн хөрөнгө оруулалт хийсний 35.9 хувийг үйлдвэрлэлийн зориулалттай тоног төхөөрөмж, 56.2 хувийг төгрөгийг барилга

байгууламжийн бүтээн байгуулалт, 7.9 хувийг бусад хөрөнгө оруулалтад зарцуулсан байна.

Түүнчлэн “Мон-Ит Булигаар ХК-ийн 2021 оны жилийн санхүүгийн тайлан”-д санхүүгийн аудитын тайланг Улиастай ван аудит ХХК-иар хийж гүйцэтгүүлсэн бөгөөд уг санхүүгийн аудитын дүгнэлтийн дагуу санхүүгийн хувьд шийдвэрлэх нилээн олон асуудал байна. Тухайлбал өмнөх өмчлөхтэй холбоотой өр төлбөрийг цэгцлэх, бараа материал, үндсэн хөрөнгийн бүртгэлийг дахин сайжруулах, түүнчлэн төлбөрийн чадварын үзүүлэлтийг хангах, компанийн үйл ажиллагааг хэвийн үргэлжлүүлж өргөтгөхөд шаардлагатай хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг компанийн хувьцаа нэмж гаргах хэлбэрээр шийдвэрлэхээр Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар оруулж шийдвэрлүүлэх санал оруулж байна.

Иймд Мон-Ит Булигаар Хувьцаат компанийн гүйцэтгэх удирдлагын баг 2021 онд төлөвлөсөн зорилтоо биелүүлэхийн тулд өөрсдийн нөөц бололцоогоо бүрэн ашиглаж, компанийн үр ашгийг нэмэгдүүлэх, хэтийн зорилгодоо хүрэх, компанийн хөгжлийг урагшлуулах үр дүнтэй алхмуудыг хийж, Монгол Улсын хуулийн хүрээнд зах зээлийн өнөөгийн байдалд зохицсон үйл ажиллагааг явуулж ажилласан гэж Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс дүгнэж байна.

3-рт. Компанийн 2021 оны санхүүгийн тайлан, түүнд хийсэн хараат бус аудитын дүгнэлтийг танилцуулах

ТУЗ-ийн дарга Б.Энхмэнд: 2021 оны жилийн санхүүгийн тайланг баталгаажуулах аудитын тайланг Улиастай ван аудит ХХК-иар гүйцэтгэсэн. Хараат бус аудитын дүгнэлтээр: Мон-Ит Булигаар ХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна гэсэн байгаа. Аудитын дэлгэрэнгүйг дүгнэлтийг тарааж өгсөн материалаас танилцах боломжтой байгаа.

4-рт. Компанийн ногдол ашиг тараах тухай ТУЗ-ийн гаргасан тогтоолыг танилцуулах

ТУЗ-ийн дарга Б.Энхмэнд: ТУЗ-ийн 2022 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн 02 тоот тогтоолын дагуу 2021 оны ногдол ашиг тараах тухай шийдвэр гарсан. Одоо уг тогтоолыг дэлгэрэнгүй уншиж танилцуулъя: “Мон-ит булигаар” хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол 2022 оны 02 сарын 11-ний өдрийн Дугаар 02 Улаанбаатар хот, Ногдол ашиг хуваарилах тухай, Монгол Улсын “Компанийн тухай хууль”-ийн 46 дугаар зүйл, “Мон-Ит Булигаар хувьцаат компанийн дүрэм”-ийн 7 дугаар зүйлийн 7.32.10 дахь заалтыг тус тус үндэслэн тогтоох нь:

Нэг. “Мон-Ит Булигаар” ХК-ийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн дүгнэлт хэтийн төлөвийг харгалзан тус компанийн 2021 оны цэвэр ашгаас компанийн хувьцаа эзэмшигчдэд олгох нэгж хувьцаанд оногдох ногдол ашгийг 600 /зургаан зуун/ төгрөгөөр тогтоосугай.

Хоёр. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2022 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдрөөр тогтоосугай.

Гурав. Ногдол ашигийг хувьцаа эзэмшигчдэд 2022 оны 07-р сарын 01-ний өдрөөс эхлэн компани дээрээ /зөвхөн 10-аас дээш хувийн хувьцаа эзэмшигчдэд/ болон Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХКомпанитай гэрээ байгуулан хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулах замаар, бэлэн мөнгө хэлбэрээр тарааж олгохыг Гүйцэтгэх захирал Б.Анхболд, Ерөнхий нягтлан бодогч Х.Лхагвасүрэн нарт зөвшөөрсүгэй.

Дөрөв. Ногдол ашиг хуваарилахтай холбогдох бүхий л үйл ажиллагааг удирдан зохион байгуулахыг Гүйцэтгэх захирал Б.Анхболд-д даалгасугай.

5-рт. ТУЗ-ийн үйл ажиллагааны зардлын төсөв танилцуулах

ТУЗ-ийн дарга Б.Энхмэнд: ТУЗ-ийн үйл ажиллагааны зардлын төсвийг танилцуулъя. ТУЗ-ийн хараат бус гишүүний цалин жилд 4 давтамжтайгаар 250,000 төгрөгийг олгохоор нийтдээ жилд 3 сая төгрөг, Бичиг хэрэг, хурлын зардалд 110,836,600 төгрөгийг төсөвлөсөн байгаагаас хувьцаа гаргах асуудалтай холбоотойгоор зөвлөх үйлчилгээний төлбөрт 100 саяыг төсөвлөсөн байгаа, бусад зардлын хувьд МХБ болон ҮЦТХТ-ийн үйлчилгээний хураамж, бичиг хэрэг, цай кофе, хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зардал багтсан байгаа.

6-рт. Компанийн 2022 оны бизнес төлөвлөгөөг танилцуулах

Гүйцэтгэх захирал Б.Анхболд: Компанийн 2022 оны бизнес төлөвлөгөө дэх зорилгын хүрээнд компанийн үйлдвэрлэл, борлуулалтын хэмжээг 2021 онтой харьцуулахад 35%-иар нэмэгдүүлэх, Үйлдвэрийн байр болон тоног төхөөрөмжид их засвар хийж, нэн шаардлагатай тоног төхөөрөмжийн шинэчлэлт хийх үүнтэй холбоотойгоор хөрөнгө оруулалтын төсөв гарсан байгаа дараагийн хуудсанд ярих байгаа, үйлдвэрийн дэргэдэх цэвэрлэх байгууламжийг ашиглалтад оруулсан байгаа төлөвлөгөөний хувьд оны өмнө бичигдсэн болохоор зарим ажлууд 1-р улиралдаа гүйцэтгэсэн байгаа. Худалдан авагч, харилцагч, гадаад түншүүдтэй харилцаагаа сайжруулж, урт хугацааны хамтын ажиллагааг бүтээх, стратегийн ач холбогдолтой шинэ харилцагчдыг нэмэгдүүлэх гэсэн зорилгын хүрээнд дараах зорилтыг тавьсан байгаа. Үйлдвэрлэл нэн шаардлагатай тоног төхөөрөмжийг нэмж авах, ашиглалтын горимыг хатуу мөрдөж ажиллуулах. Технологи сайжруулалтын туршилтыг хийж, үйлдвэрлэлд нэвтрүүлэх энэ ажил байнга хийгдэж байгаа. Түүхий эд болон химийн материалын татан авалт, сэлбэг хэрэгслийн тасалдлыг арилгаж ажиллах энэ асуудал дээр онцгой анхаарч олон харилцагчтай хамтын ажиллагааг өрнүүлж байгаа. Худалдан авагчийн сүлжээг чанаржуулж найдвартай, тогтвортой хамтын ажиллагааг бий болгох; Компанийн гадаад, дотоод маркетинг болон PR бодлогыг боловсруулах ажлын хүрээнд баг томилогдон ажиллаж байгаа бөгөөд ирэх 5 дугаар сараас төлөвлөгөөт ажлуудыг хийхээр болсон байгаа. Үйл ажиллагааг оновчтой төлөвлөж, нэгж хоорондын ажлын уялдаа холбоог сайжруулах, удирдах ажилтнуудын удирдахуйн мэдлэгийг сайжруулж нэг түвшинд хүргэхэд чиглэн бид гаднын чадварлаг мэргэжилтэнг ажиллах болно. Хүний нөөцийн чадавхийг сайжруулах, орон тоог оновчтой түвшинд барих;

2022 онд үйлдвэрт зайлшгүй шаардлагатай нийт 9 төрлийн тоног төхөөрөмж худалдан авах, сэлбэг солих, засвар үйлчилгээ хийх шаардлагатай байгаа ба нийт 676.7 сая төгрөг 2022 оны 1-р сард авсан үнийн санал дээр тулгуурлаж гаргав.

2019 оноос хойш тасралтгүй барилга байгууламжийн засвар хийсээр байгаа ба энэ онд цэвэрлэх байгууламж, үйлдвэрийн гадна тохижилт, Үйлдвэрийн байрны нийт 8564кв.м талбайн засвар хийхээр төлөвлөж, 623,2 сая төгрөгийг төсөвлөв.

Үйл ажиллагааны төлөвлөгөөгөөр бид түүхий эдэд 60,000 үхрийн ширийг 2022 оны 1 сарын байдлаар нэгж үнэ 15,000 төгрөгт, нийт 900 сая төгрөгөөр худалдан авч, гүн боловсруулах ба түүнд зарцуулагдах химийн материалын зардал 2 тэрбум гаруй төгрөг гарахаар байна.

Компанийн 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу төсөвлөсөн нийт зардлын дүн урьдчилсан байдлаар 8 тэрбум 953 сая төгрөг болсон бөгөөд үүнээс үндсэн хөрөнгөнд 1 тэрбум 299 сая төгрөг, зээл болон зээлийн хүний төлбөрт 1 тэрбум 92 сая төгрөг, үйл ажиллагааны зардал 6 тэрбум 650 сая төгрөгийг тус тус төсөвлөсөн байгаа.

Бид 2022 онд нийт 60,000 үхрийн ширийг гүн боловсруулж, бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн эрэлтэд 3 төрлийн артикль буюу хэв шинжтэйгээр үйлдвэрлэн худалдаалахаар төлөвлөж байна. Үүнд үхрийн хром, булигаар, ажлын гутлын артай хром нэр төрөл орно. Үхрийн ширний борлуулалтын орлого нийт 5.2 тэрбум төгрөг гэж урьдчилан төлөвлөж байна.

Ямааны арьс нь гутлын дотор хийгдэх гол үндсэн түүхий эд болдог ба бид ямааны вет-блю болон краст арьсыг гадагшаа экспортод гаргадаг. 2022 оны 3 сарын худалдан авах гэрээн дээр үндэслэн гаргасан тооцооллоор ямааны краст 150,000 ширхэг, нэгжийн үнэ \$3, ямааны вет-блю 100,000 ширхэг нэгжийн үнэ \$1.8-р экспортолж, нийт 2,016,000,000 төгрөгийн борлуулалтын орлогын прогностой байна.

Бид 2022 онд нийт 60,000 үхрийн ширийг гүн боловсруулж, бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн эрэлтэд 3 төрлийн артикл буюу хэв шинжтэйгээр үйлдвэрлэн худалдаалахаар төлөвлөж байна. Үүнд үхрийн хром, булигаар, ажлын гутлын артай хром нэр төрөл орно. Үхрийн ширний борлуулалтын орлого нийт 5.2 тэрбум төгрөг гэж урьдчилан төлөвлөж байна.

Ямааны арьс нь гутлын дотор хийгдэх гол үндсэн түүхий эд болдог ба бид ямааны вет-блю болон краст арьсыг гадагшаа экспортод гаргадаг. 2022 оны 3 сарын худалдан авах гэрээн дээр үндэслэн гаргасан тооцооллоор ямааны краст 150,000 ширхэг, нэгжийн үнэ \$3, ямааны вет-блю 100,000 ширхэг нэгжийн үнэ \$1.8-р экспортлож, нийт 2,016,000,000 төгрөгийн борлуулалтын орлогын прогностай байна.

7-рт. Компанийн оноосон албан ёсны нэрийг Булигаар ХК болгож өөрчлөх тухай

Гүйцэтгэх захирал Б.Анхболд: Компанийн нэрийн хувьд 1934 онд анх байгуулагдаад Булигаарын завод нэртэй байсан бөгөөд 1992 онд өмч хувьчлалын дараа Булигаар ХК гэсэн нэртэй байж байгаад 2008 онд Италичууд хөрөнгө оруулалт хийж, ажиллуулж байхдаа Итали гэсэн үгний Ит-г оруулан Мон-Ит Булигаар болгон өөрчилсөн түүхтэй.

8-рт. Компанийн хувьцааг хуваах

Ж.Эрдэнэбат: Мон-ит булигаар ХК-ийн дүрэмд зарласан болон гүйлгээнд гаргасан хувьцааны тоо одоогийн байдлаар 400'212 ширхэг байна. Монголын хөрөнгийн биржээс авсан мэдээллээр нэгж хувьцааны үнэ 2022 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн арилжааны хаалтын ханш 14'900₮ байна.

Компани хямд эх үүсвэрээс хөрөнгө оруулалт татах бодлого хэрэгжүүлж байгаа тул зөвлөх багийн зүгээс 2022 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлан дээр суурилан нэмэлт хувьцаа гаргаж санхүүжилт татахыг зөвлөсөн. Иймд компани нэмэлт хувьцаа гаргахаар төлөвлөж, бэлтгэл ажил хангуулж байна.

Нэмж хувьцаа гаргах үйл ажиллагааг хэрэгжүүлэх явцад компанийн зарласан хувьцааны тоог шинээр нэмэгдүүлж, дүрэмд оруулан, нэгж хувьцааны үнийг хуваах замаар хувьцааны тоог нэмэгдүүлэн Хувьцаа эзэмшигчдийн хурлаар батлуулах шаардлага гарсан.

Хувьцааг хувааж тоог нэмэгдүүлэх үндэслэл шаардлага нь одоогийн гол хувьцааны эзэмшигчдийн хувьцааны тоо хэмжээг бууруулахдаа огцом шингэрүүлэхээс сэргийлэх, хувьцааны үнийг хямдруулах хэлбэрээр нэмэлт хувьцааг ажилчдад болон олон нийтэд санал болгож хөрөнгө оруулалт татах, хувьцааны арилжааны хөрвөх чадварыг сайжруулах, зах зээлийн үнэлгээг өсгөх стратеги байсан. Иймд энэхүү стратегийг Компанийн тухай хууль болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн хүрээнд хэрэгжүүлнэ. Мон-ит булигаар ХК-ийн энгийн нэгж хувьцааг 1000 хувааснаар хувьцааны тоо 400'212'000 (дөрвөн зуун сая хоёр зуун арван хоёр мянга) ширхэг болно.

9-рт. Хувьцаа нэмж гаргах, түүний тоог тогтоох

Ж.Эрдэнэбат: Компанийн тухай хуулийн 42.1 болон 42.2 дахь заалтын дагуу компани 200'000'000 (хоёр зуун сая) ширхэг хүртэлх энгийн хувьцааг гүйлгээнд гаргах боломжтой болно. Эхний ээлжинд 20'000'000 (хорин сая) хүртэлх тооны энгийн хувьцааг ажилчдад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөр (ESOP) батлагдахаар гүйлгээнд гаргах боломжийг энэхүү үйл явц бий болгосон. 2022 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлан гарсны дараа олон нийтэд энгийн хувьцаа санал болгох ТУЗ-ийн эрх зүйн чадамж болон санхүүгийн тооцоолол, зарласан хувьцааны тоо зэрэг бэлэн болно. Хувьцааг олон нийтэд санал болгохын ач холбогдол нь:

- Олон улсын бизнест хүлээн зөвшөөрөгдөх чадварлаг боловсон хүчинг бүрдүүлэх боломжтой (Урамшууллын систем, опцион ашиглах);
- Компанийн бүтээгдэхүүн үйлчилгээ олон нийтэд танигдах;
- Хувьцааны зах зээлийн үнэлгээ тодорхой болсноор компанийн үнэлгээ тодорхой болох;
- Хувьцаа эзэмшигчид (компанийг үүсгэн байгуулагч нарт) тулгамдсан асуудлаас гарах гарцыг нээж өгөх;
- Ажилчдын ажиллах урамшууллын төсөл хэрэгжүүлэх боломж олгох (ESOP);
- Үйл ажиллагаагаа өргөжүүлэх, тоног төхөөрөмж, технологийн шинэчлэлийг цаг алдалгүй хийх боломж;
- Компанийн сайн засаглалыг хөгжүүлснээр олон улсад танигдаж бизнесийн нэр хүндээ өсгөх боломж.

10-рт. Компанийн дүрмийг шинэчлэн батлах

Ж.Эрдэнэбат: Компанийн дүрмийг шинэчлэх шаардлага нь энэ хурлаар хэлэлцэн батлах асуудлыг өөрчлөн оруулснаас гадна компанийн дүрэмд Компанийн тухай хуульд заасан заалтуудаас давхар оруулсанг хассан байгаа. *Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд*

зориулсан тарааж өгөх материал дахь компанийн дүрмийн өөрчлөлтүүдийг нэг бүрчлэн уншиж өгөв. Тараах материалын хавсралтаар илгээсэн байгаа./

11-рт. ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийн танилцуулга.

ТУЗ-ийн дарга А.Энхмэнд: 2019 оны 7 дугаар сард Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хуралдсанаас хойш бид барилга байгууламжийн бүтээн байгуулалт, тоног төхөөрөмжийн шинэчлэл, засвар үйлчилгээ, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх гэсэн зорилгын хүрээнд ТУЗ-ийн хараат болон ердийн гишүүдээ энэ чиглэлийн салбартаа тэргүүлэгч мэргэжилтэнг нэр дэвшүүлэн хувьцаа эзэмшигчдийн хурлаараа сонгож ажилласан. Одоо бидэнд цаашдын төлөвлөгөөний чиглэлийн хүрээнд ТУЗ-ийн хараат болон ердийн гишүүнд нэр дэвшигчдийг нэр дэвшүүлсэн байгаа. Ердийн гишүүдэд нэр дэвшигчид:

1. Батчулууны Анхболд: Мон-Ит Булигаар ХК-ийн гүйцэтгэх захирал, 2019 оны 7 дугаар сараас хойш компанийн ТУЗ-ийн гишүүнээр сонгогдон ажиллаж байгаа.
2. Батчулууны Баянжаргал: Дархан минж ХХК-ийн гүйцэтгэх захирал, 2019 оны 7 дугаар сараас хойш компанийн ТУЗ-ийн гишүүнээр сонгогдон ажиллаж байгаа.
3. Анхболдын Энхмэнд: Лугати ХХК-ийн гүйцэтгэх захирал, 2019 оны 7 дугаар сараас хойш компанийн ТУЗ-ийн даргаар сонгогдон ажиллаж байгаа.
4. Довжидын Гансүх: Мон-Ит Булигаар ХК-ийн үйлдвэрлэл хариуцсан захирал, 2019 оны 7 дугаар сараас хойш компанийн ТУЗ-ийн гишүүнээр сонгогдон ажиллаж байгаа.
5. Мягмарын Төрхүү: Булигаар трейд ХХК-ийн Гүйцэтгэх захирал, санхүүгийн болон татварын чиглэлээр төрийн болон хувийн хэвшлийн компанид олон жил ажилласан туршлагатай. Энэ жил шинээр ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшиж байгаа.
6. Цэрэндагвын Мөнхлхагва: Мон-Ит Булигаар ХК-ийн хүний нөөцийн ахлах менежер, барилга, уул уурхайн салбарт мэргэжлээрээ олон жил ажилласан туршлагатай. Энэ жил шинээр ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшиж байгаа.
7. Жадамбын Эрдэнэбат: МУИС-ийг математикч мэргэжлээр төгссөн. Үнэт цаас, брокерийн салбарт олон жил ажилласан туршлагатай. Энэ жил шинээр ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэр дэвшиж байгаа.
8. Төмөрбаатарын Болд: Украин улсын Машин байгууламжийн дээд сургуулийг инженер мэргэжлээр төгссөн. Үнэт цаас, брокерийн салбарт олон жил ажилласан туршлагатай. Энэ жил шинээр ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэр дэвшиж байгаа.
9. Чулуунбаатарын Нямдорж: Нягтлан бодогч, эдийн засагч эрх зүйч мэргэжлээр төгссөн. Санхүүгийн болон татвар, аудитын чиглэлээр төрийн болон хувийн хэвшлийн компанид олон жил ажилласан туршлагатай. Энэ жил шинээр ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэр дэвшиж байгаа.

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Хурлын дарга Б.Анхболд: Хэлэлцэх асуудлын дарааллаар одоо асуулт, хариултын хэсэг эхлэх гэж байна.

Хувьцаа эзэмшигч: Надад нэг үг байна. Үүний өмнө Гүйцэтгэх захирал Б.Анхболд, ТУЗ-ийн дарга А.Энхмэнд, ТУЗ-ийн гишүүдээ баярласан талархсанаа хэлье. Мон-Ит Булигаар компанийг өнгөрсөн 2-оос 3 жилд маш их хэмжээний хөрөнгө оруулалт хийж, засаж, бүтээн байгуулалт хийж, үйл ажиллагаа нь жигдрүүлэн дахин боловсруулсан арьс гаргаж байгаад тун их баяртай байгаа. Маш их бүтээн байгуулалт, өөрчлөлтийг хийсэн байгааг харахад их баяртай байна.

САНАЛ ХУРААЛТ:

Санал өгөх санамжийг танилцуулан санал хураалтыг эхлүүлсэн бөгөөд санал хураалт 5 минут үргэлжлэв. 10 минут түр завсарлав. Тооллогын комисс саналыг хураалтын дүнг нэгтгэв.

САНАЛ ХУРААЛТЫН ДҮНГ ТАНИЛЦУУЛАХ:

Тооллогын комиссын дарга Н.Анхцогж: Хувьцаа эзэмшигчдийн хурлын санал асуулгын тооллогын дүнг танилцуулахад бэлэн боллоо. Тооллогын комиссын тогтоолыг уншиж танилцуулъя.

Санал хураалтын дүнгийн тухай

Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.3.8 дахь заалт, Мон-Ит Булигаар ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцсэн асуудлуудаар санал өгсөн саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн саналыг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

Мон-Ит Булигаар ХК-ийн саналын эрхтэй нийт 400,212 энгийн хувьцааны 352,628 ширхэг буюу нийт саналын эрхтэй хувьцааны 88.1 хувийг эзэмшиж буй 5 хувьцаа эзэмшигч хуралд оролцсон.

Хурлаар дараах асуудлуудыг ердийн аргаар санал хураан шийдвэрлэв.

1. Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 88.1% буюу 352,628 ширхэг хувьцаатай 5 хувьцаа эзэмшигч саналын хуудсаар хүчинтэй санал өгсөн.

Хүчинтэй санал өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн 100% зөвшөөрсөн, 0% татгалзсан, 0% түдгэлзсэн байна.

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
352,628	100%	0	0%	0	0%

2. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн цалин урамшуулал, зардлын төсөв батлах тухай асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 88.1% буюу 352,628 ширхэг хувьцаатай 5 хувьцаа эзэмшигч саналын хуудсаар хүчинтэй санал өгсөн.

Хүчинтэй санал өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн 100% зөвшөөрсөн, 0% татгалзсан, 0% түдгэлзсэн байна.

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
352,628	100%	0	0%	0	0%

3. Компанийн оноосон албан ёсны нэрийг “Булигаар” ХК болгож өөрчлөх тухай асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 88.1% буюу 352,628 ширхэг хувьцаатай 5 хувьцаа эзэмшигч саналын хуудсаар хүчинтэй санал өгсөн.

Хүчинтэй санал өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн 100% зөвшөөрсөн, 0% татгалзсан, 0% түдгэлзсэн байна.

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
------------	--	------------	--	------------	--

Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
352,628	100%	0	0%	0	0%

4. Компанийн хувьцааг хуваах тухай асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 88.1% буюу 352,628 ширхэг хувьцаатай 5 хувьцаа эзэмшигч саналын хуудсаар хүчинтэй санал өгсөн.

Хүчинтэй санал өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн 100% зөвшөөрсөн, 0% татгалзсан, 0% түдгэлзсэн байна.

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
352,628	100%	0	0%	0	0%

5. Компанийн хувьцаа нэмж гаргах, түүний тоог тогтоох тухай асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 88.1% буюу 352,628 ширхэг хувьцаатай 5 хувьцаа эзэмшигч саналын хуудсаар хүчинтэй санал өгсөн.

Хүчинтэй санал өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн 100% зөвшөөрсөн, 0% татгалзсан, 0% түдгэлзсэн байна.

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
352,628	100%	0	0%	0	0%

6. Компанийн дүрмийг шинэчлэн батлах тухай асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 88.1% буюу 352,628 ширхэг хувьцаатай 5 хувьцаа эзэмшигч саналын хуудсаар хүчинтэй санал өгсөн.

Хүчинтэй санал өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн 100% зөвшөөрсөн, 0% татгалзсан, 0% түдгэлзсэн байна.

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
352,628	100%	0	0%	0	0%

Хурлаар дараах асуудлыг кумулятив аргаар санал хураан шийдвэрлэв.

7. Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох тухай асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 88.1% буюу 352,628 ширхэг хувьцаатай 5 хувьцаа эзэмшигч саналын хуудсаар хүчинтэй санал өгсөн.

Хүчинтэй санал өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн санал:

Ердийн гишүүдэд:

№	ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигчийн нэр	Саналын хувь	Кумулятив аргаар өгсөн саналын тоо
1	Батчулууны Анхболд	88.1%	352,628
2	Анхболдын Энхмэнд	88.1%	352,628
3	Батчулууны Баянжаргал	88.1%	352,628

4	Довжидын Гансүх	88.1%	352,628
5	Мягмарын Төрхүү	88.1%	352,628
6	Цэрэндагвын Мөнхлхагва	88.1%	352,628

Хараат бус гишүүдэд:

№	ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигчийн нэр	Саналын хувь	Кумулятив аргаар өгсөн саналын тоо
1	Жадамбын Эрдэнэбат	88.1%	352,628
2	Төмөрбаатарын Болд	88.1%	352,628
3	Чулуунбаатарын Нямдорж	88.1%	352,628

тус тус санал авч дээрх гишүүд Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдэд сонгогдов. Хэлэлцсэн 7 асуудлыг асуудлыг баталсан болно.

Хурлын дарга Б.Анхболд: За баярлалаа. Одоо хурлаас гарах тогтоолын төслийг нарийн бичгийн дарга О.Маралмаа танилцуулна.

Нарийн бичгийн дарга О.Маралмаа:

**Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн
тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9, Мон-Ит Булигаар ХК-ийн 2021 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлантай танилцаж, Төлөөлөн удирдах зөвлөлөөс компанийн үйл ажиллагаанд өгсөн дүгнэлтийг хэлэлцсэний үндсэн дээр 2022 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

Нэг. Мон-Ит Булигаар ХК-ийн 2021 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд Төлөөлөн удирдах зөвлөлөөс өгсөн дүгнэлтийг Нэгдүгээр хавсралт ёсоор баталсугай.

ХУРЛЫН ДАРГА

**Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2022 оны зардлын төсөв батлах тухай**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13 дахьх заалт, 2022 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

Нэг. Мон-Ит Булигаар ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны үйл ажиллагааны зардлын төсвийг Нэгдүгээр хавсралтад зааснаар баталсугай.

Хоёр. Батлагдсан төсвийн зарцуулалтад хяналт тавьж, цалин хөлс, урамшууллыг үр дүнг харгалзаж олгож байхыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга /А.Энхмэнд/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

Компанийн хувьцааг хуваах тухай

Компанийн тухай хуулийн 51 дүгээр зүйл, 62 дугаар зүйлийн 62.1.6, 63 дугаар зүйлийн 63.7 заалт, 2022 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

- Нэг. МОН-ИТ БУЛИГААР ХК-ийн нэг бүр нь 100 (нэг зуун) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 400'212 (дөрвөн зуун мянга хоёр зуун арван хоёр) ширхэг энгийн хувьцааны нэгж хувьцаа бүрийг 1000 хувааж, нэг бүр нь 10 (арван) мөнгөний нэрлэсэн үнэтэй нийт 400'212'000 (дөрвөн зуун сая хоёр зуун арван хоёр мянган) ширхэг хувьцаа болгосугай.
- Хоёр. МОН-ИТ БУЛИГААР ХК-ийн зарласан хувьцааны тоог 2'000'000'000 (хоёр тэрбум) ширхэгээр тогтоосугай.
- Гурав. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг ханган хувьцааны бүртгэлийг хууль тогтоомжийн дагуу бүртгүүлэх ажлыг зохион байгуулахыг Гүйцэтгэх захирал /Б.Анхболд/-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА

Зарласан хувьцаанаас гүйлгээнд гаргах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.3, 63 дугаар зүйлийн 63.7 заалт, 2022 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

- Нэг. Компанийн зарласан нийт энгийн хувьцаанаас 200'000'000 (хоёр зуун сая) ширхэг энгийн хувьцааг гүйлгээнд гаргахыг Мон-Ит Булигаар ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлд зөвшөөрсүгэй.
- Хоёр. Хувьцаа гаргах ажлыг хууль тогтоомжид нийцүүлэн хэрэгжүүлэхийг Мон-Ит Булигаар ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга /А.Энхмэнд/-д, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн тогтоолын дагуу холбогдох ажлыг зохион байгуулахыг Гүйцэтгэх захирал /Б.Анхболд/-д тус тус даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА

Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1, 63 дугаар зүйлийн 63.7 заалт, 2022 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

- Нэг. Мон-Ит Булигаар ХК-ийн дүрмийн шинэчилсэн найруулгыг нэгдүгээр хавсралтад зааснаар баталсугай.
- Хоёр. Компанийн шинэчлэн найруулсан дүрэмд оноосон нэрийг “БУЛИГААР” хувьцаат компани болгон өөрчилсүгэй.
- Гурав. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг Улсын бүртгэлийн ерөнхий газарт зохих журмын дагуу бүртгүүлэхийг Гүйцэтгэх захирал /Б.Анхболд/-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА

**Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
гишүүдийг сонгох тухай**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7, 77 дугаар зүйлийн 77.1, 77.4 дэх заалт, 2022 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

Нэг. Мон-Ит Булигаар ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийг дараах гишүүдийн бүрэлдэхүүнээр сонгосугай.

Төлөөлөн Удирдах зөвлөлийн ердийн гишүүдээр:

Батчулууны Анхболд
Анхболдын Энхмэнд
Батчулууны Баянжаргал
Довжидын Гансүх
Мягмарын Төрхүү
Цэрэндагвын Мөнхлхагва

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүдээр:

Жадамбын Эрдэнэбат
Төмөрбаатарын Болд
Чулуунбаатарын Нямдорж

Хоёр. Компанийн үйл ажиллагааг үр ашигтай удирдан зохион байгуулж, холбогдох хууль, дүрэм журмын дагуу ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдэд үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

Хурлын дарга Б.Анхболд: Хуралдаа идэвхтэй оролцон хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигч та бүхэндээ баярлалаа. Хурал зохион байгуулах комисс болон тооллогын комиссын гишүүддээ баярлаж буйгаа илэрхийлэн өндрөөс өндөр амжилт хүсье. Шинээр сонгогдсон гишүүд ажлын амжилт хүсэн ерөөгөөд ирэх жилдээ илүү их амжилттай уулзацгаая. Өнөөдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хаасныг мэдэгдье. Баярлалаа та бүхэндээ

Хурал 15 цаг 55 минутад өндөрлөв.

ХУРАЛ ДАРГАЛАГЧ:



Б.АНХБОЛД

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:

ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА *О. Маралмаа* О.МАРАЛМАА